ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/43/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3. Аудитын тайлан ........ 10
3.1 Ерөнхий зүйл ........ 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
3.4 Материаллаг байдал ........ 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 13
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 13
4. Аудитын илрүүлэлт ........ 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 214

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ТОГТОХ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/A4 20220309 214

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 /Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,839,163.00** | **6,059,064.00** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 3,839,163.00 | 6,059,064.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 3,839,163.00 | 6,059,064.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 767,498.00 | 637,998.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,676,665.00 | 5,296,066.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 385,000.00 | 125,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 10,000.00 | - |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **215,740,735.29** | **217,603,905.61** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 215,740,735.29 | 217,603,905.61 |
| 392 | **Биет хөрөнгө** | 181,140,734.50 | 183,128,905.61 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 47,531,817.23 | 47,531,817.23 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (9,506,363.52) | (14,259,545.28) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,252,017.00 | 25,085,856.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,611,551.10) | (15,627,254.71) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,807,522.40 | 18,381,047.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (15,034,519.81) | (15,939,027.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 130,701,812.30 | 137,956,012.30 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 34,600,000.79 | 34,475,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,524,999.21) | (1,650,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,475,000.00 | 34,475,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **219,579,898.29** | **223,662,969.61** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **2.36** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 2.36 |
| 413 | **Өглөг** | - | 2.36 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 2.36 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **219,579,898.29** | **223,662,967.25** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 219,579,898.29 | 223,662,967.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 134,391,927.40 | 134,391,927.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 134,391,927.40 | 134,391,927.40 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 17,331,670.36 | 21,414,739.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 17,331,670.36 | 17,331,670.36 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 4,083,068.96 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 67,856,300.53 | 67,856,300.53 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **219,579,898.29** | **223,662,969.61** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **138,759,634.00** | **139,795,210.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,020,390.00** | **2,933,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 2,020,390.00 | 2,933,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,020,390.00 | 2,933,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,020,390.00 | 2,933,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **136,739,244.00** | **136,862,210.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,442,344.00 | 3,317,510.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 675,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | 1,442,344.00 | 1,392,510.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 135,296,900.00 | 133,544,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,296,900.00 | 133,544,700.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **138,913,195.26** | **135,712,141.04** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **138,913,195.26** | **135,712,141.04** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **137,022,418.13** | **127,337,257.51** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **94,670,825.00** | **85,339,618.00** |
| 210101 | Үндсэн цалин | 82,216,950.00 | 60,540,762.00 |
| 210102 | Нэмэгдэл | 9,685,375.00 | 18,981,856.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,768,500.00 | 5,817,000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **11,586,172.34** | **10,936,826.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,931,091.65 | 7,734,838.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 965,981.15 | 853,396.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 711,427.55 | 682,716.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 181,413.52 | 151,443.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | **1,796,258.47** | **1,514,431.76** |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,602,226.53 | 12,327,089.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,091,266.53 | 957,709.07 |
| 210302 | Түлш, халаалт | 11,034,100.00 | 11,034,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 476,860.00 | 335,280.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **6,211,553.98** | **7,089,889.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,694,973.00 | 1,145,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,280,000.00 | 940,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 836,820.98 | 3,086,340.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 491,900.00 | 654,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 206,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,199,563.00 | 1,057,349.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 588,297.00 | - |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **523,600.02** | **1,628,640.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 330,600.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 193,000.02 | 1,628,640.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **316,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 316,000.00 | - |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **968,476.00** | **434,475.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 610,000.00 | 400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 34,476.00 | 34,475.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,143,564.26** | **9,580,719.68** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 660,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,143,564.26 | 8,920,719.68 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,890,777.13** | **8,374,883.53** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,575,000.00** | **1,750,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,575,000.00 | 1,750,000.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **315,777.13** | **6,624,883.53** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 314,547.13 | 6,624,883.53 |
| 213404 | Хөрөнгийн | 1,230.00 | - |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(153,561.26)** | **4,083,068.96** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(153,561.26)** | **4,083,068.96** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **134,391,927.40** | **67,856,300.53** | **17,485,231.62** | | **219,733,459.55** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **134,391,927.40** | **67,856,300.53** | **17,485,231.62** | - | **219,733,459.55** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (153,561.26) | | (153,561.26) |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **134,391,927.40** | **67,856,300.53** | **17,331,670.36** | - | **219,579,898.29** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **134,391,927.40** | **67,856,300.53** | **17,331,670.36** | - | **219,579,898.29** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **134,391,927.40** | **67,856,300.53** | **17,331,670.36** | - | **219,579,898.29** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 4,083,068.96 | | 4,083,068.96 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **134,391,927.40** | **67,856,300.53** | **21,414,739.32** | - | **223,662,967.25** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хугацаа:2021.12.31 /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **136,739,244.00** | **136,862,210.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **136,739,244.00** | **136,862,210.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,442,344.00 | 3,317,510.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 675,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,442,344.00 | 1,392,510.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **135,296,900.00** | **133,544,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,296,900.00 | 133,544,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **136,739,244.00** | **129,011,320.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **136,739,244.00** | **129,011,320.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **134,848,466.87** | **120,636,436.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **94,670,825.24** | **85,339,618.00** |
| 210101 | Үндсэн цалин | 70,863,100.24 | 60,540,762.00 |
| 210102 | Нэмэгдэл | 17,191,725.00 | 18,981,856.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,616,000.00 | 5,817,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **11,586,172.10** | **10,936,824.40** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,869,734.40 | 7,734,838.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 965,981.16 | 853,396.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 772,784.55 | 682,716.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 181,413.52 | 151,443.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,796,258.47 | 1,514,429.40 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12,602,226.53** | **12,327,089.07** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,091,266.53 | 962,769.07 |
| 210302 | Түлш, халаалт | 11,034,100.00 | 11,034,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 476,860.00 | 330,220.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,661,361.00** | **9,703,290.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,730,175.00 | 1,081,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,465,000.00 | 680,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 836,821.00 | 3,086,340.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,214,200.00 | 654,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 206,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,295,165.00 | 3,995,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,043,406.00** | **1,235,140.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,569,006.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 298,600.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 175,800.00 | 1,235,140.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **316,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 316,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **968,476.00** | **434,475.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 610,000.00 | 400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 34,476.00 | 34,475.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **660,000.00** |
| 210901 | Бараа үйтчилгээний бусад зардал | - | 660,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,890,777.13** | **8,374,883.53** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,575,000.00** | **1,750,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,575,000.00 | 1,750,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 315,777.13 | 6,624,883.53 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 314,547.13 | 6,515,573.53 |
| 213405 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 1,230.00 | 109,310.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **7,850,890.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **7,850,890.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **7,850,890.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 7,850,890.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 7,850,890.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | **(7,850,890.00)** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Тайлант хугацаа:2021.12.31** **/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **133,544,700.00** | **127,029,126.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **133,544,700.00** | **127,029,126.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **132,908,700.00** | **126,483,126.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **90,086,700.00** | **85,339,618.00** |
| 210101 | Үндсэн цалин | 64,622,000.00 | 60,540,762.00 |
| 210102 | Нэмэгдэл | 19,416,700.00 | 18,981,856.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,048,000.00 | 5,817,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,191,800.00** | **10,936,824.40** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,283,200.00 | 7,734,838.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 977,200.00 | 853,396.18 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 781,700.00 | 682,716.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 195,400.00 | 151,443.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,954,300.00 | 1,514,429.40 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **12,749,000.00** | **12,327,089.07** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,160,000.00 | 962,769.07 |
| 210302 | Түлш, халаалт | 11,039,000.00 | 11,034,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 550,000.00 | 330,220.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,450,200.00** | **13,449,990.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,134,200.00 | 1,081,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 700,000.00 | 680,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,956,000.00 | 2,895,340.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,800,000.00 | 4,975,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 225,000.00 | 206,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,635,000.00 | 3,611,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,736,000.00** | **3,735,130.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 2,499,990.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,236,000.00 | 1,235,140.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **35,000.00** | **34,475.00** |
| 210807 | Газрын төлбөр | 35,000.00 | 34,475.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **660,000.00** | **660,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 660,000.00 | 660,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **636,000.00** | **546,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **636,000.00** | **546,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 636,000.00 | 546,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **133,544,700.00** | **127,029,126.47** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **133,544,700.00** | **127,029,126.47** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 133,544,700.00 | 127,029,126.47 |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,317,510.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,317,510.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,004,200.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **574,500.00** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 191,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 383,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,029,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,029,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **400,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 400,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,204,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,204,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,204,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **109,310.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 109,310.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,317,510.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,317,510.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 675,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,392,510.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Номын сангийн эрхэм зорилго нь "Иргэд уншигчдын оюуны хэрэгцээг бүрэн хангахуйц чөлөөт сонголт бүхий мэдээллийн төв болох" гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Номын сангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Номын сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 138.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.04 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 135.7 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 1.01 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо..

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Номын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 3.8 | 6.1 | 2.2 |
| Үндсэн хөрөнгө | 215.7 | 217.6 | 1.9 |
| Нөөцийн бараа | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | **219.6** | **223.7** | **4.1** |
| Өр төлбөр | - | 0.0 | 0.0 |
| Засгийн газрын оролцоо | 219.6 | 223.7 | 4.1 |
| Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/ | 134.4 | 134.4 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 17.3 | 17.3 | - |
| Тайлант үеийн үр дүн | - | 4.1 | 4.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 67.9 | 67.9 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **219.6** | **223.7** | **4.1** |

Бараа материалын дансны үлдэгдэл 6.1 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө данс үнэ төлбөргүй хүлээн авсан 2.9 сая, худалдаж авсан 10.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 223.7 сая болж 4.1 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1.0 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 3.2 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 208.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 75.0 сая төгрөгөөр бууруулж 133.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 133.5 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 133.5 сая төгрөг урсгал үйл ажиллагаанд 127.0 сая төгрөгийг зарцуулж 6.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.7 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1.2 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.4 сая төгрөг нийт 3.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 3.2 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 0.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 129.6 сая төгрөгийн 12, зарлагын 6.4 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 136.0 сая төгрөгийн 13 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Өгсөн зөвлөмж : Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 136.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Номын сан | 1 | 136.0 | | | | | | | 1 | 136.0 |
| Дүн | | 1 | 136.0 | | | | | | | 1 | 136.0 |